



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 5/07

Батноров сум

┌ Ур чадварын нэмэгдэл олгох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.6 дахь хэсэг, "Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид, ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийн журам батлах тухай Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 04 дугаар сарын 09-нй өдрийн А/166, А/63, А/73 дугаар тоот тушаал, Соёлын төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.1.2, 11.1.4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Соёлын төвийн ажиллагсдын 4 дугаар сарын ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн хавсралтад заасан хувь хэмжээгээр ур чадварын нэмэгдлийг олгосугай.

2. Албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тооцож олгохыг Нягтлан бодогч (Г.Цолмонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.САРАНЗАЯА